

Цахим шууданд

ОЙН БАЯРЫН ХҮРЭЭНД...

"Монгол цэргийн өдөр", орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 101 жилийн ойг тохиолдуулан цэрэгжлийн болон спортын уралдаануудыг зохион байгууллаа. Тухайлбал, цэрэгжлийн 3 төрөлтийн тэмцээнд нийт 7 багийн 56 баг тамирчид оролцож хурд хүч, авхаалж самбаагаа сорин уралдсанаас нэгдсэн дүнгээр ахмад Ж.Балданжунай захирагчтай 1мбр тэргүүлж, хошууч Б.Хүрэлчулуун ахлагчтай штабын баг удаалж, ахлах дэслэгч Б.Галдан захирагчтай Минометын батареины хамт олон гутгаар байранд шалгарав.



Зэвсэгт хүчний 350 дугаар анги

Цэрэгжлийн буудлагын тэмцээнд тэргүүн байранд ахмад Т.Нацагдорж захирагчтай 2мбр, дэд байранд дэслэгч Б.Баасанцэрэн захирагчтай штабын баг, гутгаар байранд Э.Галдан захирагчтай Минометын батареины баг тамирчид тус тус шалгарлаа.

Ангийн аварга шалгаруулах хүчит 32 бөхийн барилдаанд түүрүү бөхөөр сумын начин ахлагч А.Далайсайхан, үзүүр бөхөөр ахлагч Г.Дашчарив, шөвөгт сумын заан ахлагч Э.Бүүвэйжаргал, дэд ахлагч А.Онон нар тус тус шалгарлаа.

Мөн бүрэлдэхүүний дунд зохион байгуулсан Сээр цохилтын тэмцээний тэргүүн байранд ахлагч А.Батбаяр, дэд байранд ахлагч О.Нямбаяр, гутгаар байранд ахлагч А.Ганпүрэв нар тус тус шалгарлаа.

Ахмад Б.ДЭРДЭНЭНИНЖ

"ЦЭВЭР ОРЧИН-ХОГГУЙ ӨЛГИЙ" АЯНЫ ХҮРЭЭНД ГАДНА ОРЧНЫ ЦЭВЭРЛЭГЭЭ ХИЙЛЭЭ



Зэвсэгт хүчний 340 дүгээр анги

Орчны болон агаарын бохирдлыг бууруулах, нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн өнгө үзэмжийг сайжруулах, хог хаягдлыг цэвэрлэх, ачиж тэвэрлэх, хог хаягдалгүй цэвэр орчинд амьдарч хэвших, хүрээлэн


буй орчиндоо хог хаяхгүй байх, зөв хандлагыг хүүхэд, залуучуудад хэвшүүлэх зорилго бүхий "Цэвэр орчин-хоггүй Өлгий" аяны хүрээнд тус анги жил бүр идэвхтэй хамрагдаж ирсэн. Энэ удаад ангийн бие бүрэлдэхүүн



ангийн байрлалаас гадагш 50 метр хүртэлх хуваарьт хэсгийн орчны цэвэрлэгээг хийж гарсан хог хаягдлыг ачиж тэвэрлэн устгалд орууллаа.

Ахлах дэслэгч Б.ДОЛГОРСҮРЭН

БАЯРЫН АРГА ХЭМЖЭЭ ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА



Дорноговь аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 101 жилийн ойн баярыг тохиолдуулан аймгийн Засаг даргын 2022 оны А136 дугаар захирамж гарган хэрэгжилтэд хяналт тавин арга хэмжээг тусгай төлөвлөгөөний дагуу үе шаттайгаар зохион явуулж байна. Дорноговь аймаг дахь Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын дунд 8 төрөлтэй цогцолбор тэмцээнийг үе шаттайгаар зохион байгуулахаас энэ сарын 14-ний энэ өдөр Сагсан

бөмбөгийн тэмцээн явагдлаа. Тэмцээнд Зэвсэгт хүчний 336 дугаар анги, Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн харьяа 090 дүгээр тусгай салбар, Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн харьяа 253 дугаар тусгай салбар, Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн харьяа 281 дүгээр тусгай байгууламж, Хилийн 0129 дүгээр анги зэрэг 12 байгууллагын 100 гаруй алба хаагчид цэргийн мэргэжлийн бэлтгэлжилтийн түвшин, хурд хүч, авхаалж самбаагаа сорьж өрсөлдлөө.

Түүнчлэн тус арга хэмжээнд аймгийн Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагууд, ахмадын хороо зэрэг байгууллагуудтай хамтран оролцсон юм. Баярын үйл ажиллагааг орон нутгийн DSB телевиз, FM-101,5, аймгийн төвүүдэд байрлах цахим самбар, хэвлэмэл зарлал, төлбөр зэргийг гарган орон нутгийн ард иргэдэд мөндчилгээг хүргүүлж сурталчлан ажиллав.

Дэд хурандаа Ж.БАТТУЛГА

МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДӨР, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 101 ЖИЛИЙН ОЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД



Ховд аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 101 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Ховд аймгийн хэмжээнд гуравдугаар сарыг "ЦЭРЭГ-ЭХ ОРОНЧДЫН САР" болгон зарласан. Сарын аяны хүрээнд Ховд аймагт үйл ажиллагаа явуулдаг Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчдын дунд "СПОРТЫН ОЛОН ТӨРӨЛТ ТЭМЦЭЭН"-ийг 2022 оны 03 дугаар сарын 11-нээс 13-ны өдрүүдэд аймгийн Засаг даргын нэрэмжит болгон зохион байгуулан явуулаа. Тэмцээнийг "Сагсан бөмбөг" эрэгтэй, эмэгтэй, "Волейбол"

эрэгтэй, эмэгтэй, "Теннис" эрэгтэй, эмэгтэй, "Шагайн хавраа" багийн, "Буудлага" багийн, "Олс таталт" багийн, "Дардс" багийн, "Шатар" гэсэн төрлүүдээр зохион байгуулсан ба уг тэмцээнд 15 байгууллагуудын 300 гаруй баг тамирчид 9 төрөлд 150 гаруй багц медалийн төлөө өрсөлдсөнөөс байгууллагын дүнгээр тэргүүн байрт 26 оноогоор хурандаа Х.Энхболд захирагчтай Зэвсэгт хүчний 123 дугаар анги, дэд байрт 37 оноогоор цагдаагийн хурандаа Д.Мөнхболд даргатай Ховд аймаг дахь Цагдаагийн газрын баг тамирчид, гутгаар байрт 42 оноогоор хурандаа Б.Алтанбадрал даргатай Баруун

бүсийн төв, Ховд аймгийн Онцгой байдлын газрын баг тамирчид шалгарч бусдыгаа манлайлав.

Мөн аймгийн Засаг даргын нэрэмжит "Марш тактик, тусгай бэлтгэлийн аварга тасаг шалгаруулах" тэмцээнд нийт 6 байгууллагын 70 гаруй алба хаагч хурд хүч, авхаалж самбаа, тэсвэр хатуужлаа сорин өрсөлдсөнөөс тэргүүн байрт ахлагч М.Уртнасан захирагчтай Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн тасаг, дэд байрт ахлах дэслэгч С.Жарденбек захирагчтай Хилийн 0130 дугаар ангийн тасаг, гутгаар байрт ахлах дэслэгч Г.Ганжаргал захирагчтай Баруун бүсийн төв, Ховд аймгийн Онцгой байдлын газрын тасаг шалгарч бусдыгаа манлайлав.

"МАРШ ТАКТИК, ТУСГАЙ БЭЛТГЭЛИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙГ ЗОХИН БАЙГУУЛАН ЯВУУЛЛАА



Өмнөговь аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Монгол цэргийн өдөр" Зэвсэгт хүчний 101 жилийн ойг угтан засаг даргын нэрэмжит аймгийн аварга шалгаруулах "Марш тактик, тусгай бэлтгэлийн аварга салаа", Даланзадгад цэргийн хүрээний аварга шалгаруулах Спортын уралдаан тэмцээн амжилттай болж өндөрлөлөө. Засаг даргын нэрэмжит Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын дунд зохион байгуулсан "Марш тактик-2022" тусгай бэлтгэлийн

аварга тасаг шалгаруулах тэмцээн 3 дугаар сарын 13-ний өдөр зохион байгуулагдаж өндөрлөлөө. Тэмцээний 1 дүгээр байрт хурандаа Ж.Амаржаргал захирагчтай Зэвсэгт хүчний 167 дугаар анги, 2 дугаар байрт дэд хурандаа Л.Амарсанаа захирагчтай Хилийн 0166 дугаар анги, 3 дугаар байрт хурандаа Б.Гантөмөр захирагчтай Хилийн 0131 дүгээр анги, хурандаа Г.Хүрэлбаатар захирагчтай

Онцгой байдлын газар тус тус эзэллээ.

Мөн Даланзадгад цэргийн хүрээний аварга шалгаруулах Спортын уралдаан 9 төрлөөр явагдсанаас нийлбэр дүнгээр 1дүгээр байрт дэд хурандаа Л.Амарсанаа захирагчтай Хилийн 0166 дугаар анги, 2 дугаар байрт хурандаа Г.Хүрэлбаатар даргатай ОБГ, 3 дугаар байрт хурандаа Мишигдорж даргатай Цагдаагийн газар тус тус шалгарлаа.

ТҮҮХТ ОЙГОО УГТАН ОЛОН ТАЛЫН АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛЖ БАЙНА



Өвөрхангай аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

"Монгол цэргийн өдөр", орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 101 жилийн ой, Монгол цэрэг НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцсоны 20 жилийн ойн баярыг тохиолдуулан Өвөрхангай аймгийн Цэргийн штаб, Зэвсэгт хүчний 113 дугаар тусгай салбар, "Арвайхээр чөлөөт суваг" телевиз хамтран Арвайхээр сумын Ерөнхий боловсролын 6 сургуулийн 60 гаруй ахлах ангийн сурагчдын дунд "АХА" танин мэдэхүйн тэмцээнийг цэрэг эх орны талаарх мэдлэг

боловсролыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор 2022 оны 3 дугаар сарын 11-ний өдөр аймгийн орон нутгийг судлах музейд амжилттай зохион байгууллаа. Мөн төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын албан хаагчдын дунд "Сагсан бөмбөг"-ийн аварга шалгаруулах тэмцээнийг эмэгтэй албан хаагчид, төрийн захиргааны байгууллагуудын удирдлагууд оролцуулан холимог багуудын "Гар бөмбөг"-ийн тэмцээнийг 03 дугаар сарын 15-ны өдөр тус тус Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн

"Соёл-спортын төв"-д амжилттай зохион байгуулж явууллаа.

Аймгийн Засаг даргаар батлагдсан төлөвлөгөөний дагуу 03 дугаар сарын 16-ны өдөр аймгийн Засаг даргын нэрэмжит "Мини марш" буюу "Цэрэг спортын цогцолбор" тэмцээн, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын албан хаагчдын дунд Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн сургуулийн төвийн районд зохион байгуулж байна.

Дэд хурандаа Ч.ВАНЧИНСҮРЭН

Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ

ЦАХИМ ХАЯГ
Батлан хамгаалах яам
Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС
"Соёмбо" редакц
"Дуулга" студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонны мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Оффцеруудын ордон Индекс: 10018
Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029, 3412 (дотуур)